



# МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2024

Улаанбаатар хот, 2025 он

# Агуулга

## 1. КОМПАНИЙН ТУХАЙ

Түүхэн замнал	5
МОСТ Групп	6-7
• “СКОП Аллианс” ХХК	8
• “ДИЖИТАЛ РЭСПО” ХХК (DIGITAL RESPO)	8
• “МОСТ КОЛЛ” ХХК (MOST CALL)	9
• “МОСТ ПАРКИНГ” ХХК (MOST PARKING)	10
	11

## 2. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төлөөлөн удирдах зөвлөл	12
Хувьцаа эзэмшигчид	13
Компанийн бүтэц, бүрэлдэхүүн	14
	15

## 3. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БИЗНЕС ЗАГВАР

Бодлого	16-18	19
Бизнесийн үйл ажиллагаа		20
• МОСТ МОНИ		21-22
• Банк Санхүүгийн байгууллага		23
• Бичил санхүүгийн байгууллага		24
• Төлбөр хүлээн авагч, үйлчилгээ үзүүлэгч		25-26
• Whitelabel үйлчилгээ		26
• Хэрэглэгчийн үйлчилгээ		27
Системийн үйл ажиллагаа		28

## 4. ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Ханшийн статистик	29	30-31
Ногдол ашиг		32

## 5. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хараат бус аудиторын захидал	33	34-35
Санхүүгийн байдлын тайлан		36
Орлогын дэлгэрэнгүй тайлан		37
Өмчийн өөрчлөлтийн тайлан		38
Мөнгөн гүйлгээний тайлан		39

# Мэндчилгээ



А. Сүхдорж  
МОСТ Финтек ХК-ийн  
ТҮЗ-ийн дарга

Бид, мэдээллийн технологи (МТ)-ийн салбарынхан, мэргэжлийн хувьд түүхийн их азтай цаг үед амьдарч, аж үйлдвэрийн IV хувьсгал, МТ-ийн Их Шилжилтийн бүтээн байгуулалтад гар бие оролцож яваа билээ.

МОСТ бол Их Шилжилт дэх бидний интеграцийн үзэл баримтлалын маань цөм юм. Санхүүгийн салбарын интеграци, санхүү ба үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын интеграци, Фиат-Крипто интеграци, төвлөрсөн бус эдийн засаг, эцэст нь хүн төрөлхтөн өөрийн бүтээж буй хиймэл оюун ухааныг эрхшээлдээ байлгаж чадах эсэх тухай олон олон асуудлын шийдэл МОСТ дээр зангидаагдах юм гэж бид харж байна.

## Mongolian Online Secured Transactions vs МОСТ – гүүр!

МОСТ Финтек-ийн суурь санааг анхлан 2006 онд дэвшүүлж, хаалттай хүрээнд Монголын арилжааны банкууд, YХО-уудад хувьцаагаа санал болгон санхүүжилтээ босгож, 2008 онд бизнесийн үйл ажиллагааг нь эхлүүлж байлаа. 2010 онд Most Money брэнд нэртэйгээр Монголын анхны цахим хэтэвч мэндэлсэн.

Бид МОСТ-ыгоо “жинхэнэ” Хэрэглэгч Төвтэй үйлчилгээ гэж цохон тэмдэглэх дуртай, учир нь бизнес тойрсон хэрэглэгч биш, хэрэглэгчээ тойрсон бизнес топологитой юм. Бизнесийн эрхлэгчдээ нэг дор зангидан цуглуулах бодлогоо хэрэгжүүлэх амар биш хэдий ч өмнөө тавьсан зорилтоосоо ухарч шантрахгүй 15 гаруй жил зүтгүүлсний эцэст үр дүнд хүрлээ. Банкууд, банк бус санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, үнэт цаасны компаниуд, төлбөр тооцооны байгууллагууд бидэнд өөрсдөө хандан залгагдах болж, бидний хэрэглэгчээ тойрсон үйлчилгээний цар хүрээ өдөр өдрөөр өсөн тэлэх замдаа шуудран орлоо.

Бүх төрлийн бүртгэл блокчэйн журнал руу шилжинэ гэдэгт бид итгэдэг. Фиатаас Крипто руу шилжих хөдөлгөөн бол эргэлт буцалтгүй. Крипто гэхээр олон нийтийн дунд одоохондоо крипто валют, койн, токены панз наймаа тойрсон ойлголт давамгайлж байгаа бөгөөд энэ нь аяндаа намжина. Оронд нь төвлөрсөн бус санхүү-эдийн засгийн дэд бүтэц ажиллаж эхлэх ёстой юм. Фиат-крипто шилжилтийн төслөө МОСТ түүштэй ахиулсаар, Крипто санхүүгийн үйлчилгээ нэг мэдэхэд орон даяар нийтийн хэрэглээ болох цаг дөхсөөр!

# КОМПАНИЙН ТУХАЙ

- ТҮҮХЭН ЗАМНАЛ
- МОСТ ГРУПП
  - “СКОП АЛЛИАНС” ХХК
  - “ДИЖИТАЛ РЭСПО” ХХК (DIGITAL RESPO)
  - “МОСТ КОЛЛ” ХХК (MOST CALL)
  - “МОСТ ПАРКИНГ” ХХК (MOST PARKING)

# Компанийн тухай

МОСТ Финтек ХК (цаашид “МОСТ”, “Компани” гэх) нь 2008 онд цахим төлбөр тооцооны дэд бүтцийг бий болгох зорилготой байгуулагдсан Монгол Улсын ууган ФИНТЕК компани юм. Компани нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш технологийн шилдэг шийдэл дээр сууриссан үндэсний хэмжээний төлбөр тооцооны дэд бүтцийг байгуулан, дэлхийн жишигт нийцсэн хэн ч залгагдан ажиллах боломжтой, оролт гаралтын нээлттэй порт бүхий суурь системээ нэвтрүүлэн 17 дахь жилдээ үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна.

Компани нь санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхэлдэггүй бөгөөд Монголбанкнаас олгосон “Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх зөвшөөрөл”-ийн хүрээнд төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлэн ажилладаг. МОСТ-ын үндсэн үйл ажиллагаа нь гүйлгээ боловсруулах буюу оролцогч талуудын, МОСТ-д холбогдсон цахим хэтэвчүүдээр дамжуулан тэдгээрийн хэрэглэгч нарын данснаас дансанд гүйлгээг хуваарилан хийх үйлчилгээ бүхий үндэсний платформ юм.

Монгол Улсын банк санхүүгийн салбар сүүлийн жилүүдэд цахим төлбөр тооцооны чиглэлд шинэ боломж, шинэ үйлчилгээг нэвтрүүлэн дэлхийн чиг хандлагатай хөл нийлүүлэн хөгжиж байна. Үүнтэй зэрэгцэн МОСТ нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ технологийн хөгжил дэвшил, хэрэглэгчийн хүсэл, шаардлагад нийцүүлэн, шинэ боломжоор тогтмол сайжруулж, финтек салбарт инновацыг нэвтрүүлэн ажиллаж байна.

Компанийн бизнесийн бодлого нь банк, санхүү, финтек, төрийн үйлчилгээ, бизнесийн бүх салбарын байгууллагуудтай харилцан холбогдох хамтран ажиллах түншлэлийн нээлттэй байх зарчимд сууриссан. МОСТ-ын үйл ажиллагаа нь салбар салбарын үйлчилгээний байгууллагууд дунд гүйлгээ боловсруулан дамжуулах, төлбөр тооцооны цогц шийдлээр хангах, big data дээр сууриссан үнэлгээ гаргаж өгөх зэрэг дундын дэд бүтэц ЭКОСИСТЕМ-ийн боломжоор хангаж, түүнд залгагдсан бүхий л мобайл апп болон хэтэвчүүдэд тус системийн боломжуудыг нээж өгдөгөөрөө ялгаатай юм.



## Алсын хараа

Фиат-Крипто ертөнцийг хамарсан цахим экосистемийг цогцлоох.



## Үнэт зүйлс

Хүний нөөц • Нээлттэй платформ • Чанар, стандарт



## Эрхэм зорилго

Хэрэглэгч төвтэй байх

## Түүхэн замнал



МОСТ ПСП ХХК нэртэйгээр үндэсний хэмжээний цахим төлбөр тооцооны “дэд бүтэц”-ийг бүтээн байгуулах зорилготойгоор Монгол Улсын ууган финтек компани болон үйл ажиллагаагаа эхлүүлэв.

2008



2009



Анхны СИМ картад цахим мөнгөний үйлчилгээ болох MobiXpress-ийг (Candy буюу одоогийн MonPay) нэвтрүүлэв.

2010



2012

Дэлхийн жишигт нийцсэн, хэн ч залгагдан ашиглах боломжтой, оролт/гаралт-ын нээлттэй порт бүхий төлбөр тооцооны үндсэн системийг Монгол Улсад анх удаа 100 хувийн дотоодын бүтэн байгуулалттайгаар гүйцэтгэж, Мост Мони үйлчилгээг олон банк, олон байгууллагын үйлчилгээг хүргэх боломжтойгоор ХХБ, Капитрон Банк, Төрийн банктай хамтран нэвтрүүлэв.



Мост Мони (Most Money) үйлчилгээ нь Монголын анхны төлбөр тооцооны апликацийн болов.

2013



2014

Банкны системээс гадна ББСБ-ын харилцагчийг Мобайл төлбөр тооцооны платформд холбож санхүүгийн үйлчилгээ үзүүлэх боломжийг нэвтрүүлсэн.



Бүх үүрэн телефоны операторууд болон Улаанбаатар Хотын Банк Мост Мони үйлчилгээнд нэгдэв.

2015



100,000 хэрэглэгчтэй болж Мост Мони үйлчилгээний шинэ хувилбараа танилцуулав.

**2016**



МОСТ Платформд төрийн үйлчилгээ болох Татвар, НӨАТ болон NFC/EMV, QR үйлчилгээг нэвтрүүлэв.

**2017**



Ард Кредит ББСБ-г МОСТ Платформд элсүүлэн, 3D POS, Corporate Gateway, Кредит оноо, Whitelabel зэрэг олон төрлийн шинэ үйлчилгээг зах зээлд гаргав.

**2018**



Онлайн зээлийн үйлчилгээг нэвтрүүлж хиймэл оюун ухааныг хөгжүүлж Кредит онооны тооцоололд ашиглаж эхлэв.

**2019**



Үнэт цаасны компаниудын үндсэн системийг МОСТ Платформд холбож, арилжааг гар утсаараа хийх боломжтой болгосноор Монгол Улсын хөрөнгийн зах зах зээлд шинэ хуудсыг нээв.

**2020**



Монголын хөрөнгийн зах зээлд ҮЦК-иудын харилцагчдыг Мобайл төлбөр тооцооны платформд холбож хүссэн цагтаа, хаанаас ч арилжаа хийх боломжийг бий болгов.

**2021**



Нийлүүлэлтийн гинжин хэлхээ, Крипто ертөнц, Үл хөдлөх хөрөнгө, Лавлах төвийн үйлчилгээ зэрэг зах зээлийн салбар руу хүрээгээ тэлэв. ММ-д хэрэглэгч 100 хувь зайнаас бүртгүүлэх боломжтой болов. Хэрэглэгч өөртөө дэд хэрэглэгч бүртгүүлж, удирдах боломжтой болов.


**2022**



Технологийн салбарыг түүчээлсэн 15 жилийн ойн босгон дээр МОСТ Финтек ХК нь олон нийтэд нээлттэй компани болов.

**2023**

# МОСТ Групп



## СКОП Алианс ХХК

Салбартаа 20 гаруй жилийн туршлагатай банк санхүүгийн секторын үндсэн системийг нийлүүлэгч "ГрэйпСити Монгол" ХХК нийлүүлэлтийн гинжин хэлхээний нээлттэй платформыг нэвтрүүлэх зорилгоор "СКОП Алианс" ХХК-ийг 2021 оны 1-р сард үүсгэн байгуулсан. 2022 оноос нийлүүлэлтийн гинжин хэлхээний бүхий л оролцогчдод төлбөр тооцооны шийдлийг нь олгож, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын нэгдсэн мэдээллийг бүрдүүлэх үүднээс "ГрэйпСити Монгол" ХХК-ийн эзэмшиж буй хувь хэмжээг МОСТ Финтек компани худалдан авснаар зах зээлд шинэ үйлчилгээгээр хүрээгээ тэлээд байна.

"СКОП Алианс" ХХК өөрийн бүтээсэн GOOD платформоор дамжуулан эцсийн хэрэглэгч, мерчант, нийлүүлэгч, санхүүгийн байгууллагуудыг холбосон нийлүүлэлтийн гинжин хэлхээний санхүүжилтийн платформыг бий болгож бүх талуудад харилцан үр ашигтай, хэрэгцээт үйлчилгээг үзүүлэх худалдааны экосистемийг хөгжүүлэхээр зорин ажиллаж байна.

Худалдаа, үйлчилгээний байгууллагын бараа материал захиалах, хүлээн авах, тэдгээр үйл ажиллагаатай холбоотой бүртгэл тооцооны асуудлуудыг технологид суурilan цогцоор шийдвэрлэн, бизнес эрхлэгчдээ хүртээмжтэй, өртөг багатай санхүүгийн үйлчилгээ үзүүлэх нь бидний зорилго юм. GOOD платформд сууриссан экосистем нь лоялти системтэй болж, урсгал зардлыг бууруулах, борлуулалтыг өсгөх, маркетингийн оновчлолыг сайжруулах, авлагын асуудлаас ангижрах, өртөг багатай санхүүжилтийн боломжуудаас сонгон бизнесийн бодит өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг бизнес эрхлэгчдэд олгож байгаагаараа давуу талтай.



- Бараа материалын захиалгын бүртгэл, тооцоо
- Технологийн цогц шийдэл
- Хүртээмж нэмэгдэх, өртөг буурах
- Борлуулалт өсөх
- Маркетинг сайжрах
- Лоялти

## “Дижитал Рэспо” ХХК (Digital Respo)

“Дижитал Рэспо” ХХК нь анх 2021 оны 8-р сарын 05-ны өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд тус компани нь мэдээллийн технологийн үйл ажиллагаа, программ хангамжийн үйлчилгээ, бизнесийн зөвлөх үйлчилгээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Тус компани нь завсрын зуучлалгүй, үл хөдлөх эд хөрөнгө болон газрын бүртгэлтэй онлайн холболттой, блокчэйн дээр тулгуурласан нотариатын үйлчилгээтэй, барилгын үйлдвэрлэлийн дамжлага бүрд хяналт тавих, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн санхүүжилт хийх, эцсийн хэрэглэгч нарт “кредит скоринг” дээр үндэслэн ипотекийн зээл олгох зорилготой платформыг байгуулахаар ажиллаж байна. Компани нь Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газрын алба, Нотариатын танхимуудтай хамтын ажиллагааг эхлүүлж тэдний мэдээлэл технологийн вендор компаниудтай холболтын гэрээ байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд Засгийн газар болон Монголын барилгын үндэсний ассоциацитай хамtran ажиллах бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байна.



БАРИЛГА



РЭСПО



ХЭРЭГЛЭГЧ



### ШИЙДЭЛ


- YXX худалдааны платформ (P2P)
- 3D, AR, VR хэрэглэгчийн интерфейс
- Цаг хэмнэлт
- Тодорхой, ойлгомжтой
- Баталгаатай, найдвартай
- Эрсдэлээс хамгаалах даатгал, санхүүгийн цогц үйлчилгээ

## “МОСТ Колл” ХХК (MOST Call)

Анхлан Аксис системс ХХК болон МОСТ Финтек ХК нь хамтран 2021 оны 3-р сарын 01-ний өдөр тусгайлан дуудлагын үйлчилгээ үзүүлэх бие даасан МОСТ Колл ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд өнөөгийн байдлаар тус компани нь дуудлагын төвийн платформын програм хангамжийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тус компани нь байгууллагын дотуур холбоо, дуудлагын төвийн систем, тусгай дугаарын дуудлага болон мессеж, имэйл, онлайн чат, веб аппликацийнд суурилсан аудио болон видео дамжуулах боломжтой Call Center, Contact Center, Cloud Customer Experience Center зэрэг бүтээгдэхүүнийг зохион бүтээж харилцагчийн хүсэл, сонирхолд нийцсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, зах зээлд танилцуулж, түүнийг амжилттай нэвтрүүлсэн байна.

МОСТ Колл ХХК нь бүх төрлийн сувгаар байгууллагад хандсан хэрэглэгчийн хүсэлт бүрийг алдалгүй хүлээн авч, шийдвэрлэхэд мэдээллийн технологийн дэвшилтэт шилдэг арга хэрэгслийг нэвтрүүлж, үйлчилгээ үзүүлж цаашид бүтээгдэхүүн үйлчилгээгээ улам сайжруулан, олон улсын зах зээлд гаргахаар зорин ажиллаж байна. Компанийн үйлчилгээг харилцагчид чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэдэг бүх төрлийн байгууллага ашиглах боломжтой.

Үүнд: Төрийн байгууллага, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эмнэлгүүд, банк, санхүүгийн байгууллага, онлайн худалдаа, захиалга, хүргэлтийн үйлчилгээ, болон гоо сайхан, үсчин, урьдчилан цаг захиалах шаардлагатай бүх төрлийн байгууллагууд байна.



## “МОСТ Паркинг” ХХК (MOST Parking)

Монголын банк, санхүү, хөрөнгийн салбарын програм хангамжийн зах зээлд үнэмлэхүй байр суурь эзэлдэг, 2000 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж буй ГрэйпСити Монгол ХХК нь 2008 онд үүсгэн байгуулагдсан үндэсний цахим төлбөр тооцооны МОСТ Финтек ХК-тай хамтран 2024 оны 2-р сарын 20-нд МОСТ Паркинг ХХК-ийг байгуулсан.

МОСТ Паркинг-н үйлчилгээ нь авто зогсоолын ухаалаг менежментийн платформ юм.

Платформыг хөгжүүлэгч компани



Цахим төлбөр тооцооны платформ



Платформын оператор компани



Үл зогсох зогсоолын менежмент

Монголын банк, ББСБ-ууд  
+26 аппликацій  
1.85 сая хэрэглэгч

Авто зогсоолын үйлчилгээ үзүүлэгч

Авто зогсоол

## Бүтээгдэхүүн



### ЗОГСООЛД ЗОРИУЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ

Зогсоолд зориулсан үйлчилгээний бүтээгдэхүүнүүдээс хэрэгцээндээ тохируулан багцлан сонгоно:

- Төлбөртэй болон төлбөргүй
- Нээлттэй болон хаалттай
- Хагас хаалттай/нээлттэй
- Зочин захиалга
- Гишүүнчлэл
- Non-Stop тохиргоо

Дуудлагын төв:

Лавлагaa, санал, гомдол хүлээн авах төвлөрсөн үйлчилгээтэй.



### ЖОЛООЧИД ЗОРИУЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ

- Non-Stop: Орлоо, Зогслоо, Явлаа!
- Машины дугаараа апп дээрээ бүртгээд л болоо!
- Зогсоолын онлайн төлбөр (урамшуулалтай)
- Дэлгүүр, үйлчилгээний төв дээр үйлчилгээ авсан бол зогсоолд тавьсан машиныхаа номерыг Кассирт бүртгүүлээд л болоо!
- Сул зогсоолын лавлагaa ба захиалга
- Зогсоолын байршлын мэдээ
- Үрдчилсан төлбөрт зогсоолын түрээс

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
- ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД
- КОМПАНИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“МОСТ ФИНТЕК” ХК нь хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурал 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хуралдалдаж ТҮЗ-ийн 9 гишүүнийг зохих журмын дагуу томилж, бүрэн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 2024 оны 12 дугаар сарын байдлаар ТҮЗ-ийн ердийн гишүүн Гэ.Тэлмэн, хараат бус гишүүн Б.Оюунжаргал нар өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт өгсний үндсэн дээр хараат бус гишүүнийг түр орлон ажиллах гишүүнээр Б.Баатармөнхийг томилон ажиллуулж байна. Компанийн зүгээс ердийн болон хараат бус гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлаар сонгох асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын бүтцэд өөрчлөлт ороогүй бөгөөд дараах хороодтой. Үүнд:

- Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо
- Аудитын хороо
- Бизнесийн бодлогын хороо



**A. Сүхдорж**

ТҮЗ-ийн дарга  
(Үүсгэн байгуулагч  
МОСТ Финтек ХК)



**Б.Баатармөнх**

ТҮЗ-ийн хараат бус гишүүн  
(Гүйцэтгэх захирал,  
Ньюком ХХК)



**Г. Тэлмэн**

ТҮЗ-ийн хараат бус гишүүн  
(Гүйцэтгэх Захирал  
Грийн Голд Финанс  
Кредит)



**С. Сүхболд**

ТҮЗ-ийн хараат бус гишүүн  
(ХАЖК хариуцсан  
Захирал  
Макс групп)



**Ч. Ганхуяг**

ТҮЗ-ийн гишүүн  
(ТҮЗ-ийн дарга  
Ард Санхүүгийн  
Нэгдэл ХК)



**Б. Мөнхцэцэг**

ТҮЗ-ийн гишүүн  
(Гүйцэтгэх Захирал  
ГрэйпСити Монгол ХХК)



**Ч. Чинбат**

ТҮЗ-ийн гишүүн  
(Гүйцэтгэх Захирал  
Жи Эс Би Капитал  
ББСБ)



**С. Оргил**

ТҮЗ-ийн гишүүн  
(Гүйцэтгэх Захирал  
МОСТ Финтек ХК)

# Хувьцаа эзэмшигчдийн бүтэц


2025 оны 1 дүгээр сарын байдлаар:

## Хувьцаа эзэмшигч

	Хувьцаа эзэмшигч	Эзэмшлийн хувь
Иргэн А.Сүхдорж		28.60%
Ардын тэтгэврийн данс ХХК		10.68%
И Ай Ти		10.68%
Ард секьюритиз үзүүлэлт ХХК		7.47%
ГрэйпСити Монгол ХХК		3.02%
Иргэн С.Оргил		6.41%
Ажилчид		6.14%
Олон нийт		27.00%

## Эзэмшлийн хувь

## МОСТ Финтек ХК-ийн хувь эзэмшлийн байдал



# Компанийн бүтэц, бүрэлдэхүүн



## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БИЗНЕС ЗАГВАР

- БОДЛОГО
- БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
  - МОСТ МОНИ
  - БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА
  - БИЧИЛ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА
  - ТӨЛБӨР ХҮЛЭЭН АВАГЧ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ
  - WHITELABEL ҮЙЛЧИЛГЭЭ
  - ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

# Үндсэн үйл ажиллагаа, бизнес загвар

МОСТ Платформ нь төлбөр тооцооны оролцогч талуудыг холбосон цогц шийдэл юм. Компани нь МОСТ Платформоор дамжуулан санхүүгийн байгууллагууд, тэдгээрийн харилцагч байгууллагууд, хувь хүмүүс болон мерчантуудад төлбөр тооцооны цогц үйлчилгээг санал болгодог.

Үнээс гадна МОСТ Платформ нь Монголбанк, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж, Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв, Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв, Татварын Ерөнхий Газар, Гааль, Төрийн мэдээллийн ХҮР, ДАН үйлчилгээ, Зээлийн Мэдээллийн Сан, Төрийн Сан, цахим гарын үсгийн сертификат олгогч зэрэг улсын хэмжээний төвлөрсөн дэд бүтцүүдтэй холбогдон ажиллаж байна.



Бидний  
Үндсэн үйл  
ажиллагаа

## Гүйлгээ боловсруулах

МОСТ нь салбар салбарын үйлчилгээний болон санхүүгийн байгууллагуудтай холбогdon төлбөр тооцооны гүйлгээг боловсруулан дамжуулдаг. Гүйлгээ боловсруулах чиглэлийн хүрээнд дараах үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

- Төлбөрийн гүйлгээний эквайринг
- Төлбөрийн гүйлгээний свич буюу сэлгэн залгалт
- Төлбөрийн гүйлгээний сеттлемэнт
- Төлбөрийн гүйлгээтэй холбогдсон санхүүгийн бус гүйлгээний боловсруулалт.

## Бидний үндсэн үйл ажиллагаа

### Төлбөр тооцооны шийдэл

МОСТ Финтек ХК нь бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй үйлчилгээний байгууллагуудад төлбөр тооцооны цогц шийдлийг хүргэн ажилладаг. Төлбөрийн шийдлийн хүрээнд дараах үйлчилгээнүүдийг санал болгодог. Үүнд:

- QR, qPOS, веб ПОС
- Урьдчилсан болон дараа төлбөрт тооцоо

### Цахим хэтэвчийн үйлчилгээ, менежмент, нээлттэй API, White Label

МОСТ Платформын өргөн боломжууд, цаашдын хөгжүүлэлт болон шинэ бүтээгдэхүүнүүдийг эцсийн хэрэглэгчид хүргэх гол суваг нь зах зээл дээрх цахим хэтэвчүүд юм. Тэдгээртэй холбогдон залгагдах нээлттэй порт болон White label буюу үйл ажиллагаагаа эхлүүлэх бэлэн хэтэвчийн загварын тусламжтайгаар МОСТ нь дараах боломжуудыг бий болгож байна. Үүнд:

- Дата аналитик дээр тулгуурласан санхүүгийн болон санхүүгийн бус үнэлгээ
- Дэд бүтэц – фиат болон крипто ертөнц
- Лавлах мэдээллийн үйлчилгээ

## Бидний ашигладаг технологийн шийдэл

- Төлбөрийн цогц шийдэл (QR, TAN code, NFC, данс суурьтай төлбөрийн гүйлгээ, вэс ПОС, deep\_link)
- Гүйлгээний цогч шийдэл (банк дотор, банк хооронд, сеттлемент, клиринг, гүйлгээ боловсруулалт)
- Дэд бүтцийн цогц шийдэл (hub үүсгэгч, аалзны тор шиг хэрсэн олон салаа холболтыг цэгцлэх, зөвхөн нэг холболтоор бүх шаардлагаа хангах, гүйлгээний өртгийг бууруулах зорилготой байгуулагдсан дэд бүтцийн шийдэл)
- Цахим хэтэвчийн удирдлагын шийдэл (хэтэвчийн whitelabel, үйлчилгээний whitelabel нээлттэй API)

## Бидний бүтээсэн үнэ цэнэ

- Анхны цахим хэтэвч, онлайн гүйлгээ, финтек, хувийн клиринг төв, данс суурьтай төлбөрийн гүйлгээ гаргагч
- Мөс хагалагч, цахим шилжилтийг эхлүүлэгч
- Цорын ганц мулти санхүүгийн байгууллага хоорондын цахим хэтэвч, цахим санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн бус байгууллага

## Бидний үйл ажиллагаа явуулж буй зах зээл

Төлбөр тооцоо, гүйлгээ боловсруулах, цахим хэтэвчийн үйлчилгээ, менежмент, API холболт

## Бид ямар стратеги баримталж байна вэ?

Банк, санхүү, финтек, төрийн үйлчилгээ, бизнесийн бүх салбарын байгууллагуудтай харилцан холбогдох хамтран ажиллах түншлэлийн нээлттэй байх зарчимд суурисан

## Бодлого

2025 он бол хамтын ажиллагаа, түншлэлийг үргэлжлүүлэх, олон нийтэд нээлттэй болсонтой холбогдуулж хөрөнгийн ухаалаг зарцуулалт, стратегийн түншүүдийн хамтын ажиллагааг өрнүүлэх, үр нөлөөгөө таниулах жил байх болно.


МОСТ нь өдийг хүртэл хэрэглэгч төвтэй үйлчилгээ үзүүлэхийн тулд бүгдэд нээлттэй байх замаар үндсний хэмжээний дэд бүтэц үүсгэж, нэгдсэн хэрэглэгчийн мэдээлэл дээр тулгуурлан хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангасан үйлчилгээ үзүүлж ирсэн үндсэн бодлогоо үргэлжлүүлэн баримтлах болно. Бүгдэд хүртээмжтэй “дундын” статусаа улам өргөжүүлэх үүднээс ХК болох зорилгodoо хүрсэн бөгөөд ингэснээр ижил төстэй үйлчилгээ үзүүлэгч, Финтекийн салбарын оролцон тоглогчид болон бусад үйл ажиллагаа эрхлэгчидтэй нээлттэй харилцан холболт хийх, хамтын ажиллагааг дэмжих зарчим баримтална. Бид өдгөө 17 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд энэ хугацаанд нөр их хөдөлмөрийн үр дүнд улсын хэмжээний дэд бүтэц, түүнийг дагасан төлбөр тооцооны өргөн боломж бүрдүүлсэн байна. Үүнийгээ цааш нь тэлэх, үйлчилгээнүүдээ цахимжуулах зорилгоор Тоон гарын үсэг гаргагч байгууллагуудтай харилцан холболт хийн нэвтрүүлнэ. Цаашид ч энэ бодлогоо баримталж, төрийн үйлчилгээнүүд цахимжиж байгааг олзуурхан хүрээгээ тэлэх хэрэгтэй. Дэд бүтэц гэдэг бол өөрөө бизнес хийдэг талбар биш, харин зах зээлийн бүхий л салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд боломж олгодог онцлогтой. Тиймээс IPO-р татан төвлөрүүлсэн хөрөнгийг тэдгээр бизнес эрхлэгчид болон төслүүдэд хөрөнгө оруулах байдлаар зарцуулах эргээд түүнээсээ гүйлгээ боловсруулалт, хөрөнгө оруулалтын өгөөж байдлаар орлогоо бүрдүүлэх хэлбэр рүү шилжиж байна. Ингэхдээ бодитой хэрэгжих нь тодорхой болсон үед төлбөрийг гаргах, хөрөнгийг аль болох өгөөжтэй байдлаар тараан байршуулах хөрөнгө оруулалтын хүртээмжтэй бодлого баримтална.

2021 оноос хойш түншлэлийн олон хэлбэрүүд гарч ирсэн, тэр дундаа АСН, Худалдааны гинжин хэлхээ, барилгын салбар, үл хөдлөх хөрөнгийн салбар, технологийн салбарын гэх мэт олон платформын хоорондын түншлэлийг байгуулж, хамтын ажиллагааны үр ашгийг гаргасан үйл ажиллагаа явуулна. Үүнд зарим салбарын шийдэл нь IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хамрагдаж байна. Бид өдийг хүртэл бүтээсэн зүйлийнхээ үр нөлөөг үзэх цаг нэгэнт ирсэн.


Бид 2022 оноос хойш шинээр хэд хэдэн компанийд хөрөнгө оруулалт хийснээр бизнесийн цоо шинэ салбарууд рүү үйлчилгээ, дэд бүтцээ тэлэх боломжийг нээлээ. Тухайлбал санхүүгийн маш тогтвортой орлого оруулж ирэх нийлүүлэгч, худалдаа үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондын гинжин холбооны платформын үйлчилгээ үзүүлэгч СКОП Аллианс ХХК, лавлах төвийн системийн үйлчилгээ үзүүлэгч МОСТ Колл ХХК, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэгч Дижитал РЭСПО ХХК нараар дамжуулан 2025 оноос эхлэн МОСТ-ын төлбөр тооцоо, дэд бүтэц, кредит оношлогооны үйлчилгээний цар хүрээ тэлнэ гэж харж байна. МОСТ Паркинг болон Дижитал РЭСПО компаниудад нэмэлт хөрөнгө оруулалт хийх саналаа ТҮЗ-д танилцуулж батлуулж чадсан маань энэ үйл ажиллагааг үргэлжлүүлж буйгийн жишиг билээ. Тухайлбал: Апп барьсан хэрэглэгч бүр бараг жолооч, жолооч бүр зогсоол ашиглана, зогсоол түрээслэнэ түрээсэнэ, худ авна/зарна, барьцаалж зээл авна, зам ашиглана, торгууль төлнө гм өнцгөөр харвал МП-МОСТ-РЭСПО синержиг ажил хэрэг болгоно. Үүний сацуу 2025 онд лавлах төвийн үйлчилгээг МОСТ Колл ХХК-д нэмэлтээр нэвтрүүлж хамтын ажиллагаатай харилцагч байгууллагууд болон бусад аж ахуйн нэгжүүдэд шинэ үйлчилгээ танилцуулах хамтын ажиллагааг өргөжүүлэх үүд хаалга нээх болно.

Сүүлийн хэдэн жил дэлхий дахинд өргөн яригдаж янз бүрийн хэлбэр, хувилbaraар ашиглагдаж туршигдаар ирсэн крипто-токены ертөнцийн талаарх ойлголт Монголд маш хурдтай эрчээ авлаа. Энэ зэргэлдээх зах зээлийг үндсэн банк санхүүгийн салбартай холбох гүүр нь МОСТ болох бодлогыг барина.

# Бизнесийн үйл ажиллагаа



## Онцлох:



Хамтын ажиллагаа

МОСТ Паркинг-тай хамтын ажиллагаа



Дижитал РЭСПО ХХК-тай хамтын ажиллагаа



# Мост Мони

МОСТ нь өөрийн хэтэвч болох Мост Мони апликацийн нийгээнийг 2010 онд зах зээлд нэвтрүүлсэн. Бусад адил төрлийн төлбөр тооцооны апликацшиуд зөвхөн тухайн банк, ББСБ, бизнесийн үйлчилгээг хэрэглэгчдээ хүргэх зориулалттай байдаг бол Мост Мони хэтэвчийн хэрэглэгч нь МОСТ Платформд холбогдсон бүхий л байгууллагын үйлчилгээг нэг дорос авч ашиглах боломжтой байдгаараа онцлог юм.

Мост Мони нь интернэт, үүрэн телефон, төлбөрийн картын сүлжээ зэрэг орчин үеийн банк ба мэдээлэл холбооны технологийн боловсронгуй арга хэрэгслийг оновчтой ашиглан, банкны төлбөр тооцооны үйлчилгээг нэгдсэн нэг виртуал орчин үүсгэх замаар харилцагч наарт хямд, түргэн шуурхай, хялбар хэлбэрээр зайнаас хүргэх зорилготой цахим үйлчилгээ юм.

## Мост Мони үйлчилгээний онцлох 5 шинж чанар

- Бүх дансыг нэг дорос. Хэрэглэгчид Мост Мони хэтэвчээр дамжуулан үйлчилгээ авдаг хамтран ажиллагч банкнуудын дансыг нэг дорос удирдаж төлбөр, тооцоо хийх боломжийг олгодог
- Төлбөр тооцооны онлайн үйлчилгээ
- 24/7 горимд ажиллана
- Ирээдүйн хөгжлийг харсан, цаашид байнга хөгжин тэлж байх бололцоо бүхий нээлттэй систем
- Санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага дундын хэтэвч бөгөөд тэдгээрийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх нэмэлт суваг

- МОНИТОРИНГ
- КЛИРИНГ СЕТЛЕМЕНТ
- СКОРИНГ
- ТАЙЛАН
- БИЗНЕС ШИНЖИЛГЭЭ
- КОЛЛ ЦЕНТР



- |   |  |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> <li>● <b>Мөнгө шилжүүлэх</b><br/>Утасны дугаар<br/>Дансны дугаар<br/>Өөрийн данс хооронд</li> <li>● <b>Худалдан авалт</b><br/>qPOS Мерчант<br/>qPOS Харилцагч<br/>NFC<br/>Цахим худалдаа</li> <li>● <b>Бичил зээл</b><br/>Онлайн зээл<br/>Нэг удаагийн хэрэглээний лимит</li> <li>● <b>Цахим бүртгэл</b><br/>ХҮР<br/>Иргэний үнэмлэх<br/>Харилцагчийг таньж мэдэх</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>● <b>Төлбөр тооцоо</b><br/>with Bill<br/>w/o Bill<br/>Хязгаар</li> <li>● <b>Цэнэглэлт</b><br/>All MNO air time<br/>Урьдчилсан төлбөрт карт</li> <li>● <b>Даатгал</b><br/>Жолоочийн даатгал<br/>Аялал<br/>Эрүүл мэнд</li> <li>● <b>Үнэт цаас</b><br/>IPO захиалга<br/>Ногдол ашиг</li> <li>● <b>Хадгаламж</b><br/>Хугацаатай хадгаламж</li> <li>● <b>Автомашины зогсоол</b><br/>Хугацаатай хадгаламж<br/>UB Parking</li> <li>● <b>Бэлэн мөнгө</b><br/>ATM<br/>FI branch</li> </ul> |
|---|--|


[info@most.mn](mailto:info@most.mn)
[Download on the App Store](#)
[GET IN ON Google Play](#)



## Мост Мони үйлчилгээний боломжүүд



### Шилжүүлэг

Бүх банкны данс руу, гар утасны дугаараар, Facebook хаягаар, өөрийн данс хооронд гүйлгээнүүдийг хийх боломжтой.



### Зээл

Зээлийн чадамжаа онлайнаар үнэлүүлээд 1 минутын дотор зээл авах боломжтой.



### Төлбөр

Бүх төрлийн хэрэглээний төлбөрөө нэг дороос төлөх боломжтой. Төлсөн төлбөрийн НӨАТ нь автоматаар бүртгэгдэнэ.



### Нэгж/карт

Аливаа урьдчилсан төлбөрт үйлчилгээ, нэгж, картаа худалдан авах боломжтой.



### ММ Family

Мост Мони үйлчилгээний үндсэн хэрэглэгчээс олгосон эрхийн хүрээнд хэрэглэгчийн данснаас зарцуулалт хийх эрхийг гэр бүлдээ олгож буй үйлчилгээ.



### Хувийн санхүүч

Хувийн санхүүгээ ухаалгаар удирдан орлого, зарлагаа төлөвлөх, хянах боломжийг бүрдүүлнэ.



### E-Shop

Онлайн дэлгүүрээс хүссэн бараа бүтээгдэхүүнээ худалдан авах боломжтой.



### QR

Бүх төрлийн төлбөрийн QR үншүүлан төлбөрөө төлөх боломжтой.



### ТАН/Токен

Transaction Authentication Number буюу нэг удаагийн кодыг ашиглан гуравдагч этгээдийн систем дээр санхүүгийн гүйлгээ хийх боломжтой. Жишээ нь Худалдаа Хөгжлийн Банк болон Капитрон банкны бүх салбар, ATM-ээс бэлэн мөнгө авах боломжтой.



### Үнэт цаас

Үг цэсийг ашигласнаар, хэрэглэгч Мост Мони апп-д холбогдсон ҮЦК-уудаар дамжуулан хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох, хөрөнгө оруулах, хөрөнгө оруулалтаасаа өгөөж хүртэх боломжтой.



### Тээврийн хэрэгсэл

Тээврийн хэрэгслийн татвар болон торгууль төлөхөөс гадна UB Parking ухаалаг зогсоолын үйлчилгээний төлбөрөө төлөх боломжтой.





info@most.mn


Download on the  
App StoreGET IN ON  
Google Play

## Банктай хамтын үйл ажиллагаа


Онцлох:




Хэрэглэгчийн тоо



Гүйлгээний тоо



Банк



## Бичил санхүүгийн байгууллагатай хамтын ажиллагаа

Онцлох:

**Онлайн зээл**

- ✓ ПОС орлого барьцаалсан зээл

**МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАУУДЫН ХОЛБОО**

- ✓ Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав


**MostMoney**

- ✓ 7 Банк Бус Санхүүгийн Байгууллага


**MOST Fintech**

- ✓ 10 ББСБ/ХЗХ элсүүлэв

Хэрэглэгчийн тоо




Гүйлгээний тоо



Зээл+кредит Скор



ББСБ



Хадгаламж Зээлийн Хоршоо



Үнэт цаасны компани



## Төлбөр хүлээн авагч, үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтын ажиллагаа

### Билл төлбөр

#### Биллер

Нийт 717 Биллер МОСТ-д бүртгэлтэй байна

✓ 2024 онд Шинээр 183



○ МОСТ-той гэрээтэй биллер



45

Цахилгаан, ус дулаан түгээх



21

СӨХ



596

Хялбар төлбөр



16

ОСЧАА

#### Биллер

2237

Улсын  
хэмжээнд

680

2023

873

2024

## Үүрэн Холбооны Оператор



Үндсэн


Шинэ

**ONDO**

## Whitelabel үйлчилгээ



Whitelabel тоо



	2023	2024
Шилжүүлэг	+1 сая	+1.9 сая
QR	+1.2 сая	+1.4 сая
Төлбөр	+160 мянга	+175 мянга
Зээл	+9 мянга	+16 мянга



## Хэрэглэгчийн үйлчилгээ

2024 онд хэрэглэгчийн үйлчилгээнд 38,339 дуудлага ирсэн бөгөөд 96.1%-н дуудлагыг амжилттай авсан.

Дуудлагын тоо 2023 онтой харьцуулахад 47.1%-р өссөн байна.

Смарт мэдэгдэл – **69,233,259** буюу өмнөх оноос **11.5%**-р буурсан

Мессеж мэдэгдэл – **339,190** буюу өмнөх оноос **16.5%**-р өссөн


Шинэ биллийн мэдэгдэл – **59,604** буюу өмнөх оноос **2.2%**-р өссөн

### Хүйс:




Дундаж нас **36.72**

### Нас:



### Тархалт:



Улаанбаатар

Орон нутаг

### Ажилладаг салбар:

Банк санхүү	23.88%
Худалдаа үйлдвэрлэл	15.28%
Эрүүл мэнд	8.67%
Боловсрол	3.71%
Технологи, Инженерчлэл	3.21%
Үул уурхай	1.85%
Бусад	43.40%

# Системийн үйл ажиллагаа

Системийн найдвартай ажиллагааны үзүүлэлт:



Системийн үзүүлэлт	Тасалдал (мин)		Нийт ажилласан (мин)	Үзүүлэлт (%)
	Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус		
Q1	20	29	129600	99.97%
Q2	25	51	131040	99.96%
Q3	20	0	132480	100%
Q4	25	22	131040	99.98%



# ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ


- ХАНШИЙН СТАТИСТИК
- НОГДОЛ АШИГ

# Хувьцааны мэдээлэл

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 508 тогтоолоор нийтэд санал болгон гаргах үнэт цаасны зөвшөөрлөө авч, 2023 оны 12 дугаар сард “Улаанбаатар хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан олон нийтэд “МОСТ ФИНТЕК” компанийн 131,211,820 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 27 хувийг олон нийтэд арилжаалж нийт 5.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлж олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон.

## Ханшийн статистик

МОСТ Финтек ХК нь 2024 оны 01 сарын 02-ны өдрийн байдлаар нэгж хувьцааны ханш 48 төгрөг байсан бол 2024 оны 12 сарын 31-ний өдөр 57.5 төгрөгт хүрч 20% өссөн үзүүлэлттэй байна.




2024 оны 7,8 саруудад нэгж хувьцааны үнэ уналттай байж 12.4 төгрөгт хүрч байсан бол 2024 оны 9 сараас 12 саруудад өсөлттэй байж 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 27 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зах зээлийн үнэлгээ	<b>27,943,257,750</b> төгрөг
Нийт гаргасан хувьцааны тоо	<b>485,969,700</b> ширхэг
Хаалтын ханш	<b>57.5</b> төгрөг

**Хувьцааны арилжаа**

2024 онд нийт 2,488 удаагийн, 5.99 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 149.6 сая ширхэг хувьцаа арилжаалагдсан байна.

Нийт арилжааны дүн	<b>5,992,377,492</b> төгрөг
Өдрийн дундаж арилжаа	<b>24,065,773,06</b> төгрөг
Нийт арилжааны ширхэг	<b>149,634,508</b> ширхэг
Өдрийн дундаж арилжааны ширхэг	<b>601,102</b> ширхэг
Дундаж ханш	<b>39,95</b> төгрөг

**МОСТ Финтек ХК-ийн хувьцааны арилжаа /ширхэг/  
/2024.01.02-2024.12.31/**


# Ногдол ашиг

МОСТ Финтек ХК -ийн Төлөөлөн Удирдах зөвлөл 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02/25 тоот тогтоолоор 2024 оны санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Компанийн зүгээс өөрсдийн бий болгосон дэд бүтэц, технологийн боломжкоо үр ашигтай үйлчилгээ байдлаар хүргэх, түүнд тулгуурлан ирээдүйд үлэмж хэмжээний ашиг авчрах төсөлт ажлуудыг хэрэгжүүлэх замаар ашигаа зарцуулах нь өнөөгийн нөхцөл байдалд илүү үр дүнтэй, ухаалаг шийдвэр хэмээн харж байна.

Цаашид МОСТ Финтек ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу зарцуулсны дараагаар үр ашигтай ажиллаж дараах зарчмыг баримтлан жил бүр ногдол ашиг хуваарилах зорилготойгоор ажиллаж байна. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх.
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх.
- Компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх.

МОСТ Финтек ХК нь ногдол ашиг тараах хэлбэр ба хугацааг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, заавар зөвлөмжийг дагаж мөрдөн ажиллах юм.



# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- ХАРААТ БУС АУДИТОРЫН ЗАХИДАЛ
- САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
- ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
- ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
- МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

# Санхүүгийн тайлан

## Хараат бус аудиторын захидал

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МОСТ Финтек ХК-ийн хувьцаа эзэмшигчид

#### Дүгнэлт

Бид МОСТ Финтек ХК (цаашид "компани" гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аudit хийлзээ.

Бид, компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "МНБЁЗ-н дүрэм" гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЁЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай залт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

#### Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай залт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр тувшиний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аudit нь байнга

▶ "Хүлэгтхүннүү аудит" ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
5-р хороо, Самбуугийн гудамж, Эм Эн таузэр, 808 тоот.  
Утас/Факс: +(976)-7014 0505

материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай залт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохиорох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хувалдаан, баримт бичгийг хурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоо явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохиорох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдэг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бутэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурсан:

И.Гураагчай  
Гүйцэтгэх вахирал  
Хүлэгтхүннүү Аудит ХХК

2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр  
Монгол Улс, Улаанбаатар хот

▶ "Хүлэгтхүннүү аудит" ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
5-р хороо, Самбууугийн гудамж, Эм Эн таузэр, 808 тоот.  
Утас/Факс: +(976)-7014 0505

6

## Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31	Өөрчлөлт төгрөгөөр	Өөрчлөлт хувиар
<b>Хөрөнгө</b>				
<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	827,868,193	774,338,031	(53,530,162)	-6.5%
Дансны авлага болон бусад авлага	7,179,063,428	3,901,219,552	(3,277,843,876)	-45.7%
Бараа материал	536,743	878,458	341,715	63.7%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,448,151,991	430,885,755	(1,017,266,236)	-70.2%
Бусад эргэлтийн хөрөнгө	1,000,000,000	1,900,000,000	900,000,000	90.0%
	<b>10,455,620,354</b>	<b>7,007,321,795</b>	<b>(3,448,298,560)</b>	<b>-33.0%</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			-	
Үндсэн хөрөнгө	759,885,234	755,258,212	(4,627,021)	-0.6%
Биет бус хөрөнгө	4,940,165,457	4,934,918,147	(5,247,310)	-0.1%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	523,451,788	1,828,094,852	1,304,643,064	3.5x
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	2,745,139,043	2,745,139,043	100.0%
	<b>6,223,502,479</b>	<b>10,263,410,254</b>	<b>4,039,907,776</b>	<b>64.9%</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>16,679,122,833</b>	<b>17,270,732,049</b>	<b>591,609,216</b>	<b>3.5%</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>				
<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
Дансны болон бусад өглөг	668,317,457	454,106,543	(214,210,914)	-32.1%
Татвар, НДШ-ийн өглөг	102,095,365	85,680,129	(16,415,236)	-16.1%
Хойшлогдсон татварын өр		17,157,119	17,157,119	100.0%
	<b>770,412,822</b>	<b>556,943,792</b>	<b>(213,469,031)</b>	<b>-27.7%</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>770,412,822</b>	<b>556,943,792</b>	<b>(213,469,031)</b>	<b>-27.7%</b>
<b>Эздийн өмч</b>			-	
Хувь нийлүүлсэн хөрөнгө	4,859,697,000	4,859,697,000	-	0.0%
Халаасны хувьцаа		(272,160,007)		100.0%
Нэмж төлөгдсөн капитал	6,795,689,845	6,795,689,845	-	0.0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,307,858,509	3,299,884,178	(7,974,331)	-0.2%
Эздийн өмчийн бусад хэсэг		154,414,071		100.0%
Хуримтлагдсан ашиг алдагдал	945,464,657	1,876,263,171	930,798,514	98.4%
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>15,908,710,011</b>	<b>16,713,788,257</b>	<b>805,078,247</b>	<b>5.1%</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>16,679,122,833</b>	<b>17,270,732,049</b>	<b>591,609,216</b>	<b>3.5%</b>
	0	0		

## Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31	Өөрчлөлт төгрөгөөр	Өөрчлөлт хувиар
Борлуулалтын орлого (цэвэр)	1,700,612,828	2,386,651,006	686,038,178	40.3%
Борлуулсан барааны өртөг	91,130,782	85,755,786	(5,374,996)	-5.9%
Нийт ашиг (алдагдал)	1,609,482,046	2,300,895,220	691,413,174	43.0%
Хүүний орлого	234,285,847	696,117,235	461,831,387	3x
Бусад орлого	-	-	-	-
Борлуулалт, маркетингийн зардал	469,611,334	562,061,592	92,450,258	19.7%
Ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал	1,181,083,851	1,416,914,689	235,830,838	20.0%
Бусад олз (гарз)	177,685	1,920,114	1,742,429	10.8x
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>193,250,394</b>	<b>1,019,956,288</b>	<b>826,705,894</b>	<b>5.3x</b>
Орлогын татварын зардал	23,428,585	97,132,105	73,703,521	4.1x
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>169,821,809</b>	<b>922,824,183</b>	<b>753,002,374</b>	<b>5.4x</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>169,821,809</b>	<b>922,824,183</b>	<b>753,002,374</b>	<b>5.4x</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	1,499,040,000	-	(1,499,040,000)	-100.0%
Орлогын нийт дүн	1,668,861,809	922,824,183	(746,037,626)	-44.7%



## Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгээр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31	3,547,578,800	-	3,026,502,644	3,308,788,509	-	(724,327,152)	9,158,542,801
Залруулсан үлдэгдэл	3,547,578,800	-	3,026,502,644	3,308,788,509	-	(724,327,152)	9,158,542,801
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	-	1,668,861,809	1,668,861,809
2023 оны 12-р сарын 31	4,859,697,000	-	6,795,689,845	3,307,858,509	-	945,464,657	15,908,710,011
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	4,859,697,000	-	6,795,689,845	3,307,858,509	-	945,464,657	15,908,710,011
Тайлант үеийн ашиг (алдагдал)						922,824,183	922,824,183
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчид гарсан өөрчлөлт		(272,160,007)		(7,974,331)	154,414,071	7,974,331	(117,745,936)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							-
2024 оны 12-р сарын 31	4,859,697,000	(272,160,007)	6,795,689,845	3,299,884,178	154,414,071	1,876,263,171	16,713,788,257



## Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(171,556,844)	119,855,115
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(4,772,661,569)	98,775,094
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,715,586,379	(272,160,007)
Валютын ханшны зөрүү	1,042	(364)
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>771,369,008</b>	<b>(53,530,162)</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>56,499,185</b>	<b>827,868,193</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>827,868,193</b>	<b>774,338,031</b>





📞 7505 2727  
✉️ info@most.mn  
📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо  
Сэнтрал Тауэр, 13-н давхар, 1313 тоот

Улаанбаатар хот, 2025 он